



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/246.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.3.7, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5, 16.5.5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/23 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах нягтлан бодогч (А.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 20... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын
хавсралт

ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын үндсэн зорилго нь Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийн захиран зарцуулалтад тавих дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулах талаар өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Өмч хамгаалах зөвлөл нь “цаашид” зөвлөл гэх байнгын үйл ажиллагаатай байна.

1.3. Зөвлөлийн үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

1.4. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Татварын тухай багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, болон Засгийн газар, төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.5. Зөвлөл нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, ажиллах нөхцөл боломжоор хангана.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Даргын эзгүйд түүний даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргалж болно.

2.3. Зөвлөлийн хуралдаан ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

2.4. Зөвлөлийн ээлжит хуралдааныг хагас жил тутамд зохион байгуулна. Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. Асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.5. Ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын товлосноор гишүүдийн гуравны нэг болон удирдлагын санал болгосноор зарлан хуралдуулна.

2.6. Зөвлөлийн гишүүн асуудлыг хуралдаанд танилцуулна. Тухайн асуудлыг боловсруулсан албан хаагч нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зорилгоор хуралдаанд байлцаж болно.

2.7. Хуралдаанд хууль тогтоомжид нийцсэн, зохих судалгаа, тооцоо нотлох баримтад үндэслэн, санхүүгийн болон хөрөнгийн холбогдох бусад мэдээлэл бүхий материалыг эд хөрөнгийн зохицуулалтын холбогдох журамд нийцүүлэн батласан асуудлыг хэлэлцэнэ.

2.8. Зөвлөлийн шийдвэрийг тусгасан хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

2.9. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ажлын 3 өдөрт багтаан бичиж хуралдааны дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.10. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

2.10.1 Хурал болсон огноо, эхэлсэн, завсарласан, дууссан цаг минут

2.10.2 Хурал болсон газар

2.10.3 Хурлын ирц, хуралд оролцоогүй гишүүдийн нэр, шалтгаан

2.10.4 Хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан болон байлцсан этгээдийн нэр, албан тушаал

2.10.5 Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан тавьсан асуулт, хариулт, санал, дүгнэлт танилцуулга, тайлбар, хурлаас гарсан шийдвэр.

2.11. Зөвлөл санал боловсруулах, шийдвэр хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан маягт, үндсэн хөрөнгө хүлээн авах шилжүүлэх, ашиглалтаас хасах, устгах баримт болон зохих бусад материалыг ашиглана.

2.12. Зөвлөлийн тухайн жилд гүйцэтгэсэн ажил, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг дараа жилийн 01 дүгээр сард багтаан ЭЭХХЗГ-ын даргад танилцуулж, баталгаажуулна.

Гурав. Өмч хамгаалах зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь төрийн өмчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2. Зөвлөл нь өмчийн харилцааны асуудлаар авч хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын төсвийг боловсруулж төсөвт тусгуулах арга хэмжээ авсан байна.

3.3. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн байгууллагын эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах шилжүүлэх, актлах, данснаас хасах зэрэг асуудлыг судалж дараах байдлаар дүгнэлт зөвлөмж гаргана. Үүнд:

3.3.1. Байгууллагын чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө олж авах болон эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, хөрөнгийн тоо хэмжээ, үнийн доод хязгаар техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж;

3.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөр тооцоонд олж авсан хөрөнгө, төслийн шугамаар бий болсон эд хөрөнгийг бүртгэх бол хөрөнгийн чанар байдлыг харгалзан элэгдэл, хорогдлыг тооцон ашиглах хугацааг тогтоосон дүгнэлт;

3.3.3. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх бол хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж дүгнэлт;

3.3.4. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах бол хөрөнгийг худалдах доод үнийн санал бүхий дүгнэлт;

3.3.5. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг актлах, данснаас хасах бол үндэслэл, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалгасан дүгнэлт;

3.3.6. Эд хөрөнгийн дотоод тооллогын дүнгээр дутагдсан, маргаантай илүүдэлтэй, ашигладаггүй хөрөнгийн шалтгааныг тогтоосон дүгнэлт:

3.3.7. Байгууллагын даргад тухайн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж гаргана.

3.4. Байгууллагын эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, актлах, данснаас хасах асуудлыг өмч хамгаалах зөвлөл судлан дүгнэлт гаргах бөгөөд Агентлагийн даргын тушаалаар шийдвэрлэнэ. Өмч хамгаалах зөвлөл шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

3.5. Газрын дарга нь зөвлөлийн зөвлөмж дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

3.5.1. Эрх барих дээд байгууллагаас зөвшөөрөл авсан байх;

3.5.2. Эрх бүхий байгууллагаас баталсан эд хөрөнгийн зохицуулалтын журамд заасан материалын бүрдлийг бүрэн хангасан байх;

3.6. Зөвлөл нь эрх бүхий байгууллагын эд хөрөнгийн зохицуулалтын шийдвэрийг Газрын даргын тушаалаар комисс томилон хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд албан бичгээр хүргүүлэх үүрэгтэй.

3.7. Зөвлөл нь шийдвэрийн дагуу шилжүүлэх хөрөнгийг актаар хуваалцах, акталж данснаас хасах хөрөнгийг ангилж үнэ тогтоон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах, сэлбэг, материал болгон ашиглах, устгах хөрөнгийг устгалын акт үйлдэн данснаас хасах ажлыг зохион байгуулна.

3.8. Зөвлөл нь үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж холбогдох санал дүгнэлтийг Газрын даргад тавьж, шийдвэрлүүлэх эрхтэй.

3.9. Зөвлөл нь Агентлагийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эд хогшлын ашиглалт хамгаалалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана.

3.10. Хөрөнгө олж авах зардлын төлөвлөлт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулахад хяналт тавина.

3.11. Төрийн өмчийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, эвдэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ авах, зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцох асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

3.12. Ажилтан, албан хаагч бүртэй эд хөрөнгө эзэмших гэрээ байгуулан хяналт тавьж, ажиллаж болно.

Дөрөв. Бусад

4.1. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон өмчийн харилцаатай холбоотой бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

4.2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тус зөвлөлийн үйл ажиллагаанд хийсэн жилийн эцсийн үнэлгээний дүнг үндэслэн Өмч хамгаалах зөвлөлийн гишүүдэд, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгож болно.

4.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны “Журам батлах тухай” 86 дугаар тогтоолд заасан урамшууллыг олгохдоо, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын үр дүнг харгалзан, нэг удаагийн хуралдааны үнэлгээг 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөр тогтоож, хуралд оролцсон тоо, ажлын үр дүнгээр тооцож олгоно.

--ooOOoo--